

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛАЛ” АРГА ХЭМЖЭЭНИЙ
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ
/ЭХ НЯРАЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ/**

2025 оны 06 сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2025 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв эх үүсвэр, сая төг		
Нэг. Хууль тогтоомж, эрх зүйн орчныг сайжруулах						
1.1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрт үеийн нөхөн сэргээх эмчилгээ үзүүлэх тасаг, нэгжийг байгуулах	Нөхөн сэргээх эмчилгээний кабинетийн үйл ажиллагааг сайжирсан байна.	Эрүүл мэндийн даатгалаар үнэгүй	Эрүүл мэндийн даатгалаар үнэгүй	2025 оны эхний 5 сарын байдлаар уламжлалт, сэргээн засах тусламж, үйлчилгээг нийт үзлэг- 3572 Амбулатори үзлэг-2898 Тасаг-677 Үүнээс оношоор нь авч үзвэл: -Хийн өвчин-550 хүн -Эмэгтэйчүүдийн өвчин –731 -Хүүхдийн өвчин –1135 -Хэсэг бусад өвчин –298 -Дээд биеийн өвчин -5 -Шижин-111 Эмчилгээний үр дүнг сэтгэл хангамжийн судалгаагаар үнэлдэг. Их биеийн цахилгаан зүү-115 Хүүхдийн толгойн бариа-90 Төөнүүр-164 Усан зүү-12 Доргиох массаж-4 Хүүхдийн хүзүүний иллэг-2 Шивүүр-5 зэрэг тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах	60

					төвөөр үйлчлүүлж буй хүүхдүүдэд яаралтай түргэн тусламжийн үйлчилгээ авах, эмнэлзүйн тусламж үйлчилгээ авах шаардлагатай үед төрөлжсөн мэргэжлийн эмч дуудах, дуудлагын тусламж үйлчилгээ авах, өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааг зохицуулахаар хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.	
1.2	Нярайн эмч нарыг тасралтгүй чадавхжуулах	Хүүхдийн 20 эмчийг чадавхжуулсан байна	Байгууллагын зардал	-	2025 оны 04 сард ЭНЭҮТ болон ЭХЭМҮТ-ийн эмч нар ХУД-ийн 25 өрхийн эмнэлгийн эмч нар “Хүүхдэд зонхилон тохиолдох эмгэгийн оношилгооны зарчмууд” сэдэвт сургалтыг ЭНЭҮТ-д зохион байгуулж өрхийн эмнэлгийн 56 эмч хамрагдсан ба АУ-ны доктор, клиникийн профессор, Улаанбаатр бүсийн менежер, ЭМЯ-ны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлөийн дарга, ХАТТАН тэргүүн, ЭНЭҮТ-ийн зөвлөх эмч Ш.Энхтөр “Хүүхдийн амь тэнссэн төлөвийн тусламжийн зарим асуудлууд” сэдвээр, АУ-ны магистр, клиникийн профессор, зөвлөх зэргийн эмч, ЭХЭМҮТ-ийн Нярайн эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч Ч.Нарантуяа “Нярайн эмгэгүүд”, АУ-ны магистр, клиникийн профессор, зөвлөх зэргийн эмч, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн чих, хамар, хоолойн мэс заслын тасгийн эрхлэгч Б.Дэлгэрмаа “Хүүхдэд зонхилон тохиолдох чих хамар хоолойн эмгэгүүд”, АУ-ны магистр, клиникийн профессор, тэргүүлэх зэргийн эмч, ЭНЭҮТ-ийн хүүхдийн мэс заслын эмч Ж.Адьяасүрэн “Хүүхдэд зонхилон тохиолдох мэс заслын эмгэгүүд” сэдэвт сургалтыг орсон. Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх үндэсний хэмжээний сургагч багш бэлтгэх сургалтанд нярайн эмч Э.Тунгалаг, Отгонзаяа, Ринчин нар хамрагдсан. Европын Хүүхдийн эмч нарын нийгэмлэгээс Словени улсын Портороз хотод 2025 оны 2 сарын 28-с 2025	65

					оны 3 сарын 1-ны хооронд зохион байгуулсан Integrative Medical Approach to Allergy and Atopic Dermatitis сэдэвт сургалт болон хэлэлцүүлэгт Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвйн Хүүхдийн Дотрын тасгийн эрхлэгч Э.Намуун Монгол улсаас нийт 3 эмчийн хамт оролцсон. Тус сургалтанд нийт 15 улс орны 300 гаруй хүүхдийн эмч, харшлын эмч арьсны эмч нар хамрагдсан ба Монгол улсаа төлөөлөн хүүхдийн харшлын өвчний хэлэлцүүлэгт амжилттай оролцож, Европын Хүүхдийн эмч нарын нийгэмлэгийн Ерөнхийлөгч Массимо Мантованитай гэрээ хийж дараагийн удаа зохион байгуулагдах хэлэлцүүлэгт Монгол улсаас эмч нарыг цахим хэлбэрээр оролцуулахаар тохиролцсон. Монтенегро улсад 2025 оны 6 сарын 12-нд Европын Хүүхдийн эмч нарын нийгэмлэгээс зохион байгуулагдах Хөхний сүүний ач тус сэдэвт сургалт болон хэлэлцүүлэгт Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвийн эмч, ЭЭДЗ нар хамрагдсан. Тус хэлэлцүүлэгт 2025 оны 2 сард Словени улсад болсон Европын Хүүхдийн эмч нарын нийгэмлэгээс зохион байгуулсан сургалт дээр нийгэмлэгийн Ерөнхийлөгчтэй хийсэн хэлэлцээрийн дагуу Монгол улсаас нийт 25-30 эмч нарыг цахим хэлэлцүүлэгт нээлттэй оролцуулахаар болсон.	
Хоёр. Тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх						
2.1	Хүүхэд асрах газрын нялх, балчир насны хүүхдийн бие бялдар, хоол тэжээл, далд өлсөглөнг тандах судлах, хариу арга	Тандалт судалгаа хийсэн тайлан	-	-	Нялх, балчир насны хүүхдийн бие бялдар, хоол тэжээл, далд өлсөглөнг тандах судалгааг хийсэн. Тогооч, эцэг эх, хүүхэд гэсэн 3 бүлэг хүмүүсийн шим тэжээлийн мэдлэгийг үнэлэхдээ асуумж судалгааны аргаар дамжуулан үнэлсэн. Тогооч нараас судалгаа авахдаа асуумжийн аргийг ашиглан Баянгол, Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн 30-н цэцэрлэгээс судалгаа авсан. Судалгааны асуумж маань ерөнхий судалгаа, мэдлэг хандлага, хүүхдийн	50

	хэмжээг эрүүлжүүлэх	авах			хооллолт гэсэн үндсэн 3-н хэсгээс бүрдсэн. Судалгааны асуулт нээлттэй-4 асуулт, хаалттай зэрэглэлтэй-2, хаалттай 12 асуулт бүхий 18 асуултаас бүрдэнэ. Харин эцэг эхчүүдээс судалгаа авахдаа Хан-Уул дүүргийн 250-р цэцэрлэгийн ахлах бүлгийн 20-н эцэг эхээс авсан. Судалгааны асуулт нь нээлттэй- 3, хагас хаалттай- 3, хаалттай зэрэглэлтэй-2, хаалттай- 9 асуулт бүхий 17 асуултаас бүрдэнэ. Тогооч болон эцэг эхчүүдээс авсан судалгааны үр дүнг харвал тогооч, эцэг эхчүүдийн шим тэжээлийн мэдлэг харьцангуй бага байсан. Мөн түүнчлэн шим тэжээлийн талаар мэдээлэл, зөвлөгөөг 50% интернетээс авдгийг харахад дийлэнх нь баттай эх сурвалжаас мэдээлэл авч чаддаггүй харагдсан. Хоолны цэс шинэчлэх болон хоногийн илчлэгийг тооцоход тогооч нарт тулгарч байсан асуудал нь хоол зүйч байхгүйтэй холбоотой байсан. Тиймээс цэцэрлэг болгонд хоол зүйч шаардлагатай гэж үзсэн. Мөн бидний авсан асуумж судалгаанд дутагдалтай тал байсан. Энэ нь тухайн үед хэрэгцээтэй гэж асуумжиндаа оруулсан асуулт маань судалгааны зорилгот тус болоогүйгээс гадна судалгаанд оролцогчид зарим асуултандаа хариулаагүй. Энэ нь бодит үр дүн гарахад саад болсон гэж үзэж байна. Цаашдаа асуумжийн аргаар судалгаа авахдаа судалгааны асуултыг оновчтой боловсруулах хэрэгтэйг мэдэж авсан. Боловсруулсан хөтөлбөрийнхөө дагуу 3-4 настай хүүхдэд сургалт явуулж үзэхэд 3 настай хүүхдийн анхаарал удаан төвлөрөхгүй, байсан ч 4 настай хүүхдүүдтэй ижил хичээлд идэвхтэй оролцож байсан. Харин 4 настай хүүхдүүдэд хичээл ороход илүү хялбар байсан төдийгүй заасан хичээлийг сайн ойлгож байсан. Мөн асуусан асуултад сайн хариулж хичээлд идэвхтэй оролцож байсан. Ингэж хүүхдэд хичээл орсны үндсэн дээр сургалтын хөтөлбөрөө илүү хялбар	
--	------------------------	------	--	--	--	--

					сонирхолтой болгосон. Сургалтаар дамжуулан 3-4 настай хүүхдүүдийн ялгааг олж харсан. Сургалтынхаа хөтөлбөрийг видео хичээл болгон интернетэд байршуулахад эцэг эхчүүдээс их санал хүсэлт ирсэн. Хүүхдүүд видео хичээлийг сонирхон үзэж байсан ч төдийлөн сайн анхаарлыг нь татаж чадаагүй. Тиймээс видео хичээлээ илүү сонирхолтой, өнгө үзэмжтэй цуврал хичээл буюу видео контент хэлбэрээр хийхийг санал болгосон. Эдгээрээс дүгнэж үзэхэд цаашид зөвхөн хүүхдэд шим тэжээлийн боловсрол олгох бус цэцэрлэгийн тогооч, багш, эцэг эхчүүдэд зориулсан цогц сургалтын хөтөлбөр боловсруулан сургалт явуулбал илүү үр дүнтэй гэж үзсэн.	
2.2	Хөгжлийн хоцрогдолтой, эрсдэлтэй хүүхдэд зориулсан тусгай дэмжлэг, эрт үеийн оролцооны хөтөлбөрийг олон нийтийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлэх	Олон нийтийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлсэн эрт үеийн оролцооны ажиллагааны тоо нэмэгдсэн байна	-	-	Илт таталтын шинжгүй 5 нярайд тархины цахилгаан бичлэг хийж, таталтыг эрт үед оношилж, эмчилсэн. Гипокси-ишемийн шалтгаант энцефалопатитай 16 нярайд тархины цахилгаан бичлэг хийж, таталтын голомтыг үгүйсгэсэн нь эмчилгээг цаг алдалгүй эхлүүлэх нөхцлийг бүрдүүлж чадаж байна. Зунгагт хахах хамшинжтэй 1 нярай , уушигны үрэвсэлтэй 6 нярай (үүнээс артерийн битүүрээгүй цорго, зууван цонх нээлттэй-6 нярай) амьсгал гачаалын хам шинжтэй 8 нярайд төрснөөс хойш 7 хоногийн дотор iNO 20 ppm-ээр 3 хоног эмчилгээ хийхэд эмнэлзүйд хүчилтөрөгчийн ханамж сайжирч, уушигны артерийн даралт ихсэлт нь эмнэлзүй болон зүрхний ЭХО-д 48-72 цагийн дотор бууж байгаа нь эмчилгээний үр дүн богино хугацаанд үзүүлж байна. -Нярайн скрининг шинжилгээ Түнхний эход нийт 1900 Type B-395 нярай Type C-0 нярай оношлогдсон.	70

					-Зүрхний скрининг буюу хөдөлгөөнд тэсвэртэй пульсоксиметрээр нярайн баруун гар, зүүн хөлд сатураци 1900 үзсэн. -64 нярай зүрхний эход харуулахад 13 нярай зүрхний төрөлхийн гажиг оношлогдсон. - Сонсголын нийт 850 нярайд шалгасанаас 24 нярайг сонсгол давтан шалгуулахаар зөвлөгөө өгч чих хамар хоолойн эмчийн хяналт, үзлэгт явуулсан. - Нүдний улаан рефлекс 1800 нярайд шалгаснаас улаан рефлекс сул илрэлтэй 48 нярай ЭХЭМҮТ-ийн нүдний эмчид явуулсанаас 1 нярай төрөлхийн болорын цайлт оношлогдсон. Хромосомын өвчнийг ураг үед нь эрт илрүүлэх Пренатал үеийн илрүүлэг /PAPP-A, HCG/ шинжилгээг хийж үр дүнг 14 жирэмсэн эхэд үзсэн байна.	
Гурав. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх						
3.1	Осол гэмтлээс сэргийлэх, нэн ялангуяа хүүхэд өндөрөөс унаж гэмтэх, амь насаа алдахаас сэргийлсэн, цонхны хамгаалалт тор байрлуулах талаар зөвлөмж, мэдээлэлийг хүргэх	Осол гэмтлээс сэргийлэх сургалт сурталчилгаа зохион байгуулсан байна	-	-	Эх, нярай үндэсний төв нь Осол гэмтлээс сэргийлэх сарын хүрээнд байгууллагын ойр орчмын цас мөсийг арилган 7 удаагийн их цэвэрлэгээ хийж хальтарч унах осол гэмтлээс сэргийлэх ажилласан. Мөн цас орсон тухай бүрд харуул хамгаалагч нар цасыг цэвэрлэдэг. Эмнэлгийн гаднах шатанд болон хальтарч унах эрсдэлтэй газруудад хальтархаас сэргийлсэн наалт зөвлөмж байршуулж хальтарч унахаас сэргийлэн Амбулаториор үйлчлүүлэгч болон хэвтэн эмчлүүлэгч нарт осол гэмтэлээс сэргийлэх, унаж гэмтэх болон хоолны хордлого, томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээлэлийг 16 удаагийн давтамжтай тараан өгч ажиллаа. Нийт амбулаториор үйлчлүүлэгч 2380 иргэн, хэвтэн эмчлүүлэгч 416 иргэнд 5 төрлийн сурталчилгааны материал 3000 ширхэгийг хэвлэн тараасан.	75

					Осол гэмтлээс сэргийлэх, нэн ялангуяа хүүхэд өндөрөөс унаж гэмтэх, амь насаа алдахаас сэргийлсэн, цонхны хамгаалалт тор байрлуулах талаар зөвлөмж мэдээллийг сар бүрийн давтамжтайгаар 5 удаа шинэчлэн байршуулсан. ➤ Төвийн цахим хуудас, ➤ Хан-Уул эрүүл мэндийн төв, ➤ Олон нийтийн цахим сүлжээ болон Facebookийн Эрүүл мэндийн боловсрол олгох нэгдсэн групп, ➤ Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II групп, ➤ Хан-Уул дүүргийн 21-р хорооны оршин суугчдын групп, ➤ Буянт Ухаа-2 хороолол, ➤ Шүрт хотхоны групп, ➤ Өлзийт хорооллын оршин суугчдын групп Нисэх, яармаг оршин суугчдын групп зэрэг олон дагагчтай групп дээр байршуулж нийт 30000 хүн хандалт хийсэн.	
Дөрөв. Хүүхдэд ээлтэй аюулгүй						
4.1	Олдмол хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлэх, эрт илрүүлэгийг зохион байгуулж олон нийтийн мэдээлэлийг хэрэгслээр түгээх	Эрт илрүүлэг үзлэгийн өвчлөлийн тайлан гарсан байна.	Эрүүл мэндийн даатгалаар үнэгүй	Эрүүл мэндийн даатгалаар үнэгүй	Олдмол хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлэх, эрт илрүүлэгийг зохион байгуулж ажилласан.Үүнд: ✓ Монгол улсын хэмжээнд Улсын гуравдугаар төв эмнэлэг (УГТЭ)-тэй хамтран ЭНЭҮТ-ийн Хүүхдийн зүрх судас, ангиографийн эмч Т.Мөнхтулга зүрхний хэм алдагдалтай 5 хүүхдэд электрофизиологийн оношилгоо, эмчилгээ хийснээс 4 хүүхдэд зүрхний хэм алдагдлыг түлэх эмчилгээ, 1 хүүхдэд хөлдөөх аргаар эмчилгээ хийгээд байна. ✓ ЭНЭҮТ-д Ангиографийн оношилгоо, эмчилгээнд 57 хамруулснаас 38 хүнд зүрхний титэм судасны оношлогоо, эмчилгээ хийсэн.	65


					✓ Зүрхний титэм судасны хүнд хэлбэрийн нарийсалтай 5 хүнд ангиопластик мэс засал болох стент тавьсан. ✓ Эмэгтэйчүүдийн тасгийн багтай хамтран 17 хүнд умайн хоргүй леймиома хавдрын судас бөглөх эмчилгээг амжилттай хийсэн. ✓ УГТЭ-тэй хамтран зүрхний хэм алдагдалтай 5 хүүхдэд электрофизиологийн оношилгоо, эмчилгээ хийснээс 4 хүүхдэд зүрхний хэм алдагдлыг түлэх эмчилгээ, 1 хүүхдэд хөлдөөх аргаар эмчилгээ хийгээд байна. ✓ Зүрхний ЭХО оношилгоог 2200 хүүхдэд хийж, зүрхний төрөлхийн гажигтай 52 хүүхдийг илрүүлсэн. Зүрхний хэм алдагдалтай 20 хүүхдийг оношилсон. Ховдлын дээрх түгшээ (SVT)-тэй 8, WPW синдромтой 5 хүүхдийг хяналтад авсан. ✓ Тус төвд төрсөн 2800 нярайд зүрхний ЭХО оношилгоог хийж байна. ✓ Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөнд нэгдэж, 6 настай 2300 хүүхдийн зүрхний цахилгаан бичлэг (ЭКГ)-ийг уншиж, өөрчлөлттэй 852 (11.3%) хүүхдэд зүрхний ЭХО оношилгоо хийж, 41 хүүхдэд зүрхний төрөлхийн цоорхой шинээр оношлогдож, 11 хүүхдийг УГТЭ-т мэс заслын эмчилгээнд эрт үед нь илгээсэн байна. Баянхонгор аймгийн 6 настай 1900 хүүхдийн зүрхний цахилгаан бичлэгийг уншиж байна. ✓ Зүрхний төрөлхийн гажигийн 97 тохиолдлыг оношилж, хяналтанд авсан. Зүрхний хүнд зэргийн зүрхний төрөлхийн хавсарсан гажиг нийт 6 оношилж хагалгаанд оруулж эрүүлжүүлсэн байна. Бүрэн АВ канал хөхрөлттэй хавсарсан хүнд гажиг ЭНЭҮТ–д оношлогдож Солонгос	
--	--	--	--	--	---	--

					улсын эмнэлэгт хагалгаанд орж эрүүл болсон. Тетрадофалло оношоор хагалгаанд орж эрүүлжсэн. Бусад гажигтай нийт 11 хүүхэд хагалгаанд орсон) ✓ Хүүхдийн яаралтай тусламжийн тасгийн хяналтад аминд аюултай хэм алдагдал болох Ховдлын дээрх түгшээ хэм алдалт (SVT)-тай 9 хүүхэд байдаг бөгөөд 5 удаа хүүхдийн эмч нарын багтай хамтран амь тэнсэн үеийн яаралтай тусламж үзүүлж ажилласан. Эмийн эмчилгээний давтамж, зай холдож байгаа. ✓ Хүүхдийн нарийн мэргэшлийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгээр - Нийслэлийн СХД-н 188-р цэцэрлэгт 2025.05.07-08-ны өдөр бага, дунд , ахлах, бэлтгэл бүлгийн нийт 27 бүлгийн 630 хүүхдэд, зүрхний судасны эмч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн зүрхний урьдчилан сэргийлэх үзлэгийг 23 хүүхдэд хийсэн байна. Үүнээс: 6.6% (42) нь өсөлтийн хоцрогдолтой, 54.7% (345) шүд эмчлүүлэх шаардлагатай, 7.1% (45) уруул болон хэлний хөвч богино ✓ Ерөнхий мэс заслын эмчийн үзлэг: Эрэгтэй хүүхдүүдэд тээрхийн арьсны нарийсал- 25, ахлах болон бэлтгэл ангийн хүүхдүүдэд ШЕШ , шимэгч хорхойн шинжилгээ өгөхөд 7 хүүхдэд шимэгч хорхой эерэг +/- гарсан. Үзлэгээр илэрсэн өөрчлөлт бүрийг тухайн хүүхдэд болон багш, сургуулийн эмчид тухай бүрд нь тайлбарлан зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа. Цаашид урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөгөөг хүүхэд бүрд өгөв. Эмийн эмчилгээ хийлгэх шаардлагатай хүүхдүүддээ эмийн эмчилгээ цаг тухай бүрд нь бичиж өгсөн.	
--	--	--	--	--	---	--

				✓ Баянхонгор аймгийн 26 сургуулийн 1910 хүүхэд, Дорноговь аймгийн 18 сургуулийн 1052 хүүхэд, Хан-уул дүүргийн 11 сургуулийн 3500 хүүхдэд зүрхний эмгэг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, өвчлөлийг эрт илрүүлэх үзлэгийн хүрээнд хийгдсэн ЗЦБ-ийг ЭНЭҮТ-ийн хүүхдийн зүрхний эмч Т.Мөнхтулга, Т.Тэгшжаргал нар авч дүгнэсэн бөгөөд үүнээс ЗЦБ-т өөрчлөлттэй -1267 хүүхдэд зүрхний ЭХОКГ хийснээс зүрхний төрөлхийн гажиг илэрсэн-42, судсан дотуурх мэс засал болон нээлттэй мэс засалд орох шаардлагтай-8, хавхлагын хөнгөн зэргийн өөрчлөлттэй-138, хэм алдалттай -11, диспансерын хяналтанд байх шаардлагатай 28 хүүхдийг хяналтандаа аваад байна. ✓ Зөвлөх поликлиникийн Чих, хамар, хоолойн кабинет 2025.01.01-2025.06.01 хооронд 5927 хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлснээс 480 хүүхэд чих өвдсөн гэсэн зовууртай байсан. Эдгээр хүүхдүүдийн чихэнд шингэн хурсантай холбоотойгоор сонсгол олдмолоор буурсан бөгөөд үүнээс 163 хүүхэд хэвтэн эмчлүүлж эмийн эмчилгээгээр 54 хүүхэд, 109 хүүхэд мэс ажилбар болон мэс заслын тусламж үйлчилгээ авсан байна. Амбулатороор эмчилгээ зааж эдгэсэн хүүхэд 317 байна. Амбулаторийн хяналтанд одоо байгаа хүүхдийн тоо 32 байна.	
Нэгдсэн дүгнэлт	Нэгдсэн тайланг хугацаанд нь	-	-	Тус арга хэмжээний хүрээнд 4 зорилт 6 зүйлийн хүрээнд зохион байгуулсан ажлын гүйцэтгэл 65 хувьтай хэрэгжиж байна. Нярайн эмч нарыг чадваржуулах сургалтыг нийт 5 удаа зохион байгуулсан. Нярайн болон хүүхдийн эмч нарыг	65

	хүргүүлсэн байна.			хамруулсан.Нийт 125 эмч хамрагдсан. Нөхөн сэргээх дараах эмчилгээг хийж байна.үүнд: Хүүхдийн толгойн бариа-90 Төөнүүр-164 Усан зүү-12 Доргиох массаж-4 Хүүхдийн хүзүүний иллэг-2 Шивүүр-5 Олдмол хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлэх, эрт илрүүлэгийг зохион байгуулж нийт 2500 хүүхдийг хамруулсан. Урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг олон дагагчтай 12 пэйж хуудсууд дээр байршуулж нийт 42500 хүн хандалт хийж мэдээлэл авсан байна.	
--	----------------------	--	--	--	--

Хавсралт: Төвийн пейж хуудас болон зурагт дэлгэцүүдээр дамжуулан зөвлөмж мэдээлэл хүргэсэн байдал:



“НЯРАЙН СЭХЭЭН АМЬДРУУЛАЛТ” сэдэвт сургалт



Төвөөр үйлчлүүлж буй иргэд, хэвтэн эмчлүүлэгч нарт сурталчилгаа хийж буй байдал:



ЕБС-ын сурагчдад сургалт, сурталчилгаа зохион байгуулсан байдал:

